

ХОВД АЙМАГ ЗЭРЭГ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2026 оны 5 дугаар
сарын 11-ний өдөр

Дугаар 05

Алтан тээл

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭГ ТОГТООХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.4, 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 62 дугаар зүйлийн 62.2 дахь заалт, Татварын ерөнхий хуулийн 7.2.23, 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн 9.2.1, 9.2.2, Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан “Аргачлал батлах тухай” 2018 оны 7 дугаар сарын 19-ний өдрийн 192, А/243 дугаар тушаалыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын есдүгээр хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрт мөрдөх Хог хаягдлын хураамжийн хэмжээг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлэхийг сумын Засаг дарга Б.Баатарбилэг, Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Э.Сүхбаатар нарт даалгаж, иргэд олон нийтэд сурталчлах, хураамжийг батлагдсан хэмжээгээр орон нутгийн төсөвт төвлөрүүлэн ажиллахыг сумын Татварын Улсын байцаагч (Г.Эрдэнэтуяа), Байгаль орчны хяналтын Улсын байцаагч (Н.Болортуяа), Байгаль хамгаалагч (М.Нацагдорж), багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 03 сарын 30-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

4. Уг тогтоолыг “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА

Ч.ОДСАЙХАН

**Зэрэг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2026 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн
05 дугаар тогтоолын хавсралт**

ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ

№	Хог хаягдлын үйлчилгээний хураамж төлөгч	Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ /Сараар/		Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээ /Жилээр /	
1	Төвлөрсөн халаалттай болон галлагаатай орон сууц, гэр хорооллын айл өрх	700		8,400	
2	Дулааны станц	30,000		240,000	
3	Төрийн банк	5,000		60,000	
4	Хаан банк	5,000		60,000	
5	Албан байгууллага	5,000		60,000	
6	Зочид буудал, амралтын газрууд	15 хүртэл ортой	12,500	15 хүртэл ортой	150,000
		15-30 ортой	16,000	15-30 ортой	192,000
		30-аас дээш ортой	20,000	30-аас дээш ортой	240,000
7	Аялал жуулчлалын бааз	25,000		300,000	
8	Ресторан, гуанз, кафе, кароаке	20 хүртэл суудалтай	4,000	20 хүртэл суудалтай	48,000
		20-50 хүртэл суудалтай	5,000	20-50 хүртэл суудалтай	60,000
		50-аас дээш суудалтай	6,000	50-аас дээш суудалтай	72,000
9	Талх, нарийн боорцог, хэрчсэн гурил, хиам, зайрмаг, цэвэр усны цех болон бусад жижиг үйлдвэрлэл эрхлэгч	3,000		36,000	
10	Үсчин, ахуйн үйлчилгээ, оёдлын цех	3,000		36,000	
11	Халуун усны газар	3,000		36,000	
12	Шатахуун түгээх станц	10,000		120,000	
13	Дугуй засвар, авто угаалга, засвар	3,000		36,000	
14	Дэлгүүр, Эмийн сан	10,000		120,000	

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 5 дугаар
сарын 22-ны өдөр

Дугаар А/44

Улаанбаатар
хот

ТУШААЛД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Журам, загвар батлах, үнэ тогтоох тухай” Хууль зүйн сайд (хуучин нэрээр)-ын 2015 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/189 дүгээр тушаалын 2 дахь заалтын Монгол Улсын “Жолоочийн үнэмлэх”-ний үнэ 12 500 төгрөг /арван хоёр мянга таван зуун төгрөг/ гэсний дараа “өөртөө үйлчлэх автомат киоск машинаар 25 250 төгрөг /хорин таван мянга хоёр зуун тавин төгрөг” гэж нэмсүгэй.

2.Энэ тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Цагдаагийн ерөнхий газрын дарга, дотоодын цэргийн командлагч, хошууч генерал Ж.Болдод, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батбямбад тус тус даалгасугай.

САЙД

С.АМАРСАЙХАН

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 5 дугаар
сарын 25-ны өдөр

Дугаар А/98

Улаанбаатар
хот

ЖУРМЫН ХАВСРАЛТ ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.6, 48 дугаар зүйлийн 48.3, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэг, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны А/41 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн дүрмийн 4.17 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/155 дугаар тушаалаар баталсан “Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журам”-ын 3.16 дахь хэсэг болон уг журмын нэгдүгээр хавсралтыг тус тус хүчингүй болгосугай.

2.Энэхүү тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв /Д.Нарансүх/-д даалгасугай.

САЙД

Т.АУБАКИР

МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2026 оны 5 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар А/127

Улаанбаатар
хот

ЖУРАМД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалт, Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн 16.1.1, 16.1.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3 дахь хэсэг, 60 дугаар зүйлийн 60.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 5 дугаар сарын 23-ны өдрийн А-138 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-ын 1 дүгээр хавсралтын 11.1² дахь заалтын “Нийслэлийн үнэт цаас” гэсний дараа “, аймгийн үнэт цаас**” гэж, “ногоон орон сууц худалдан авах, эсвэл барих зорилго бүхий төгрөгөөр олгосон зээл байна.” гэсний дараа “**Аймгийн үнэт цаас нь сүүлийн гурван жилд Монгол Улсын нэгдсэн төсөвт төвлөрүүлсэн орлогын (арифметик) дундаж дүнгийн 50.0 хувиас хэтрэхгүй хэмжээтэй, тодорхой эргэн төлөлтийн хуваарьтай бөгөөд төлбөрийн үүргийн гүйцэтгэл нь аливаа төслийн үр дүнгээс хамаарахгүй, Улсын Их Хурлаас тогтоосон өрийн хязгаарын хүрээнд төсвийн орлогоос эргэн төлөгдөх нөхцөлтэй байх шаардлагыг хангасан байна. Тухайн үнэт цаас нь дээрх шаардлагыг бүрэн хангасан эсэхийг Монголбанк тогтоогоогүй тохиолдолд аймгийн үнэт цаасны эрсдэлийн жинг тодорхойлоход бусад үнэт цаастай ижил зохицуулалтыг баримтална.” гэж тус тус нэмсүгэй.

2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Банкны хяналт шалгалтын газар (Ц. Дамдинсүрэн)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

С.НАРАНЦОГТ

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД, БОЛОВСРОЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2026 оны 5 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар А/90, А/60

Улаанбаатар
хот

ТУШААЛ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн “Журам батлах тухай” А/506, А/266 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

2.Хүчингүй болсон тушаалыг холбогдох журмын дагуу захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн сангаас хасуулах арга хэмжээ авахыг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн захиргааны удирдлагын газар (Д.Мөнгөнтуул) -т даалгасугай.

ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙД

Т.АУБАКИР

БОЛОВСРОЛЫН САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН